

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-4

<i>1.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	3
<i>2.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	3-4

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны
2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 20 цаг 47 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Даваасүрэн, Б.Жавхлан;

Чөлөөтэй: Ц.Анандбазар, Ж.Батсуурь, Х.Булгантуяа, С.Ганбаатар, Ш.Раднаасэд, Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн.

Нэг.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Батмөнх, А.Болортуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 20 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч О.Номинчимэг, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Өрийн удирдлагын тасгийн дарга Л.Эрдэнэбадрах, “Нийслэлийн орон сууцны корпорац” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал М.Говьсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Батмөнх, А.Болортуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл, арга хэмжээ нь Өрийн удирдлагын тухай хуулийн 28¹ дүгээр зүйлийн 28^{1.1}, 28^{1.3}-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд тус төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зориулалтаар гаргах Нийслэлийн гадаад үнэт цааст зориулж 2024 оны төсвийн жилд Засгийн газрын өрийн баталгаа гаргахыг Монгол Улсын Засгийн газарт зөвшөөрсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 20 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 06 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 20 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
20 цаг 47 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүдийн оройн мэндийг айлтгая. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Амартүвшин гишүүн, Одонтуяа гишүүн, Тогтохсүрэн гишүүн, Өнөрболор, Баделхан гишүүн Пүрэвдорж, Батжаргал гишүүн, Мөнхбаатар гишүүн, Сандаг-Очир гишүүд хүрэлцэн ирсэн байна. Ингээд хуралдаан нээснийг мэдэгдье. 2 асуудал байгаа. 1 дүгээр асуудал Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, эцсийн хэлэлцүүлэг байгаа. 2 дахь асуудал Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл байгаа.

Нэг. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Ингээд Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж эхэлье. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулаарай. Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусгах, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл хуулийн төсөл эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа.

Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ингээд хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир нэгдсэн хуралдаанд танилцуулна. Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

20.48 цаг

Хоёр. Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хоёрдогч, 2 дахь асуудал Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хүрэлцэн ирсэн байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын газрын дарга Номинчимэг, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Тулга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Өрийн удирдлагын хэлтэст тасгийн дарга Эрдэнэбадрах, Нийслэлийн орон сууцын корпорац ХК-ийн гүйцэтгэх захирал Говьсайхан гэсэн бүрэлдэхүүн оролцож байгаа юм байна.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төсөл болон хуулийн төслийн талаарх танилцуулгыг та бүхэнд бас тараасан байгаа. Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу нэгдсэн хуралдаанаар гүйцэтгэн боловсруулах чиглэл өгсний дагуу санал явуулах байгаа. Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллын уншиж танилцуулъя.

Тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1.Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих Сэлбэ төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл, арга хэмжээ нь Өрийн удирдлагын тухай хуулийн 28¹ дүгээр зүйлийн 28¹.1, 28¹.3-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд тус төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зориулалтаар гаргах Нийслэлийн гадаад үнэт цааст зориулж 2024 оны төсвийн жилд Засгийн газрын өрийн баталгаа гаргахыг Монгол Улсын Засгийн газарт

зөвшөөрсүгэй. Замын хөдөлгөөний гэж үү? Дахиад уншаадах. Нэгдүгээрх нь эхний хэсэг дээр нь болбол Нийслэл Улаанбаатар хотын замын хөтөл хөдөлгөөний түгжрэлийг бууруулах таслал гээд байгаа юм байна шүү. Ийм өөрчлөн найруулах санал байна.

Санал хураалтыг явуулъя. Энэ санал хураалтыг дэмжье гэсэн байдлаар санал хураалт. Ажлын хэсэг саналын томъёолол гүйцэд сонссон байх тийм ээ. Болж байна гэж байгаа биз. Санал хураалт. Санал хураалтад 10 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж 60 хувиар дэмжигдлээ. Ингээд хууль, тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Байнгын хорооноос гаргах танилцуулгыг Өнөрболор гишүүн танилцуулна. Ингээд хууль тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

20.53 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

